

**ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН 2024 ОНЫ НЭГДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 дугаар сарын 16

Дугаар 03

Улаанбаатар хот

**Журмуудын шинэчилсэн
найруулга батлах тухай**

Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн 9.6.9 дахь заалтыг удирдлага болгож, тус хуралдааны хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 2024 оны 03 сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэдийн Оролцооны Нэгдэл Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг зохицуулах журам (Шинэчилсэн найруулга)-ыг 1-р хавсралтаар баталсугай.
2. ИОН Намаас төрийн сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүдийн тандалт үнэлгээний тухай журам (Шинэчилсэн найруулга)-ыг 2-р хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ИОНН-ын Төлөөлөгчдийн Танхимын 2023 оны тавдугаар хурлын 02 дугаар тогтоол, зургаадугаар хурлын 02 дугаар тогтоол, тэдгээрийн хавсралтыг тус тус хүчингүйд тооцсугай.





ИОНН-ын Толоогочийн Танхимын
2024 оны НЭГДҮГЭЭР хурлын
03-р тогтоолын 2-р хэсэргүй

ИОН НАМААС ТӨРИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИХЭЭ ИЛЭРХИЙЛСЭН ГИШҮҮДИЙН ТАНДАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ЖУРАМ

(Шинэчилсэн найруулга)

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журам нь ИОН Намын Дүрмийн 17.2-д заасны дагуу ИОН Намын гишүүд төрийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг намын Тандалт Үнэлгээний Ажлын хэсгээс (TYAX) үнэлэх үйл ажиллагаа, түүнтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Тандалт үнэлгээний Ажлын хэсгийг дараах үе шатанд Намын дараах шатны удирдлагын тушаалаар Төрийн сонгуульд нам нэр дэвшүүлэх ажиллагааг эхлүүлэх хуульд заасан хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулна. Үүнд:

1.2.1 Улсын Их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийн тандалт үнэлгээний ажлын хэсгийг Намын даргын тушаалаар;

1.2.2 Аймаг, нийслэл, дүүргийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийн тандалт үнэлгээний ажлын хэсгийг тухайн шатны Танхимын даргын тушаалаар;

1.2.3 Сум, хороо, багийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийн тандалт үнэлгээний ажлын хэсгийг Сум, хорооны салбарын даргын тушаалаар;

1.2.4 ИОНН-ын салбар байгуулагдаагүй аймаг, дүүрэгт намаас нэр дэвших тохиолдолд Иргэдийн оролцооны нэгдэл намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу тухайн Танхимыг түр орлож ажиллах эрх олгогдсон хурал буюу хамтарсан хурлаас томилогдсон салбарын даргын тушаалаар тус тус байгуулна.

1.3 Энэ журмын 1.2-т заасан тушаалд Тандалт үнэлгээний ажлыг хүлээлгэн өгөх хугацааг заах бөгөөд энэ хугацаа нь тухайн сонгуулийн нэр дэвшилтийг шийдэх хурлаас 2-оос доошгүй хоногийн өмнө байх ёстой.

1.4 Тандалт үнэлгээнд орж буй гишүүний тандалт үнэлгээний эрэмбийн дүнг тухайн нэр дэвшилтийн асуудлыг шийдвэрлэх намын хурал болохоос дор хаяж 48 цагийн өмнө гишүүний намын цахим системд бүртгэлтэй имейл хаягаар илгээж мэдэгдэнэ.

1.5 Тандалт үнэлгээг нэг сонгуулийн нэр дэвшилтэд зориулж нэг удаа явуулна.

Хоёр. Тандалт үнэлгээний ажлын хүрээ

2.1 Тандалт, үнэлгээний ажлын хэсэг Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс хүлээж авсан нэр дэвшигчдийн жагсаалтын хүрээнд ажиллана.

2.2 Тандалд үнэлгээний ажлын хэсэг нь дор дурдсан эрэмбийг гаргана. Үүнд:

2.2.1 Ерөнхий эрэмбэ буюу Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс хүлээж авсан жагсаалтад буй бүх гишүүний эрэмбэ;

2.2.2 Тойргийн эрэмбэ буюу гишүүний Дотоод сонгуулийн төв ажлын хэсэгт өргөдөл гаргахдаа сонгосон нэг буюу хэд хэдэн тойрог дахь эрэмбэ;

2.3 Тандалт үнэлгээний ажлын хэсэг энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан эрэмбийг тус ажлын хэсгийг томилсон намын удирдлагад энэ журмын 1.3-т заасан хугацаанд хүлээлгэн өгч, тандалт үнэлгээнд хамрагдсан гишүүдэд мөн өдөртөө илгээх ба Тандалт үнэлгээний дүгнэлтийг тухайн нэр дэвшигчдийг батлах намын хуралд танилцуулна.

Гурав. Нэр дэвшигчийг эрэмбэлэх үндсэн үзүүлэлтүүд

3.1 Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс намын дүрэм журам, сонгуулийн хуулийн шаардлагыг хангасан нэр дэвшигчдийн жагсаалтыг хүлээж авсны дараа Тандалт үнэлгээний ажлын хэсэг дараах 4 үзүүлэлтээр тандалт үнэлгээг явуулна. Үүнд:

3.1.1 Дотоод үйл ажиллагааны оролцооны үзүүлэлт: Намын хурал, зохион байгуулалт, дотоод сонгууль, дүрмийн дагуу явагдах бусад үйл ажиллагаанд оролцсон оролцоо, багаар ажилласан байдал;

3.1.2 Нээлттэй үйл ажиллагааны үзүүлэлт: ИОНН-аас төрийн сонгуульд нэр дэвшигч нь намын аль нэг шатны байгууллага, намын гишүүдийн санаачилгаар зохион байгуулсан улс төрийн болон бусад нээлттэй үйл ажиллагаа, сургалтуудад олны өмнө гарч ажилласан болон олон нийтийг татан оролцуулах үүрэг гүйцэтгэж ажилласан байдал;

3.1.3 Нийгмийн сүлжээн дэх үзүүлэлт: Нийгмийн сүлжээний орчин дахь өөрийн хөтөлдөг нэг буюу хэд хэдэн цахим хуудасны идэвхи, хувь хүний нэр, хийж буй ажлын танигдалт ба намын цахим хуудас дахь идэвхи;

3.1.4 Бодлогод нөлөөлөх үзүүлэлт: ИОНН-аас боловсруулах хуулийн төсөл, бодлогын шийдлийн төслийг ганцаараа болон бусадтай хамтарч боловсруулсан, шийдэлд санал оруулсан, шийдлийн төслийг туршиж үнэлгээ шүүмж өгсөн, шийдлийн төслийн талаар олон нийтийн санаа

бодлыг цуглуулсан, бодлогын шийдэл гаргахад шаардлагатай судалгаа хийж намын гишүүдэд танилцуулсан эсэх.

Дөрөв. Эрэмбэлэх

4.1 Тандалт үнэлгээний ажлын хэсэг нь энэхүү журмын журмын 5-р зүйлд заасан үнэлгээ хийх аргачлалаар энэхүү журмын 3.1-д заасан жагсаалт дурдагдсан намын гишүүн бүрийн авсан нийт оноог гаргаж онооны ихээс бага руу жагсаах замаар ерөнхий эрэмбийг, тойрот саналаа өгсөн гишүүдийг эрэмбэлж тухайн тойргийн эрэмбийг гаргана.

4.1.1 Ерөнхий эрэмбэнд нэг гишүүн нэг удаа дурдагдана.

4.1.2 Нэг гишүүн нэг буюу хэд хэдэн тойрот эрэмбэлэгдэж болно.

4.2 Оноо тэнцсэн гишүүдийг Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс ирсэн нэрсийн дараалалд тухайн гишүүдийн байрлаж буй дэс дараагаар байрлуулна.

4.3 Хэрэв гишүүн Дотоод сонгуулийн төв ажлын хэсэгт өргөдөл гаргахдаа тойрог сонгоогүй бол түүнийг зөвхөн ерөнхий эрэмбэд оруулна.

4.4 Энэхүү журмын 2.2.1, 2.2.2-т заасан ерөнхий эрэмбэ, тойргийн эрэмбийн жагсаалтад Тандалт үнэлгээний ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах ба тэдгээр жагсаалтад үнэлгээний дүнг гаргасан хурлын тэмдэглэл, бусад нотлох баримтыг хавсаргасан байна.

Тав. Үнэлгээ хийх аргачлал

5.1 Гишүүний тандалт үнэлгээний дүнг энэ журмын 3.1-д заасан үндсэн дөрвөн үзүүлэлтээр гаргаж 100 хүртэлх нийт оноогоор дүгнэнэ.

5.2 Тандалт үнэлгээ хийхдээ үндсэн үзүүлэлт бүр дээр хамгийн дээд оноо авч чадах гишүүний амжилтыг хэмжиж болохуйц үзүүлэлтээр эхлээд тогтоож, тухайн гишүүнд тус үзүүлэлтийн дээд оноог өгнө. Үзүүлэлт бүр дээр өөр өөр гишүүн дээд оноо авч болно.

5.3 Аль нэг үзүүлэлт дээр дээд оноо авсан гишүүний хүрсэн амжилтыг тухайн үзүүлэлтийн дээд онооны тааз болгон ашиглах бөгөөд бусад гишүүдийн оноог тус таазтай харьцуулан жишиж гаргана.

5.4 Албан тушаал, улс төрийн нэлөө зэргээс шалтгаалан нэг буюу хэд хэдэн үзүүлэлтээр бусдаас хол илүү гарч буй лидерийн амжилтыг энэ журмын 5.2-д заасан дээд онооны тааз болгон авч үзэхгүй бөгөөд тухайн лидерт дээд оноо авсан гишүүнтэй адил оноо өгч эрэмбийн хувьд урд нь жагсаана.

Зургаа. Мэдээллийн хүрээ



6.1 Тандалт үнэлгээний ажлын хэсэг аливаа гишүүнд үнэлгээ өгөхдөө Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс нэр дэвшигчдийн өргөдөл авч эхлэх өдрөөс өмнөх 12 сарын хугацааны мэдээлэлд үндэслэх ба дараах өгөгдлүүдийн хүрээнд ажиллана. Үүнд:

- 6.1.1 Намын гишүүн нэр дэвшигчээр бүртгүүлэхээр Дотоод сонгуулийн төв ажлын хэсэгт ирүүлсэн өргөдөлдөө хавсаргасан гишүүний өөрийн тодорхойлолт тайлан, түүнд дурдагдсан эх сурвалж;
- 6.1.2 Соошл хаяг (Facebook, Twitter, Instagram болон Tik Tok)
- 6.1.3 Намын албан ёсны пэйж болон орон нутгийн салбарын пейж түүний мэдээллүүд
- 6.1.4 Намын архивын баримт материал;
- 6.1.5 Намын албан ёсны имейл дэх дата мэдээлэл;

6.2 Тандалт үнэлгээний ажлын хэсэгт намын бүх шатны сонгуульт албан тушаалтан, ажлын албаны ажилтан шаардлагатай мэдээллийг саадгүй гаргаж өгөх үүрэгтэй. Үүнд, дараах мэдээлэл заавал багтсан байна:

- 6.2.1 Гишүүний болон хуримтлал бүрдүүлэгч гишүүний татвар төлөлт;
- 6.2.2 Хуулийн дагуу өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;
- 6.2.3 Дотоод сонгуульд нэр дэвшилт, сонгогдсон байдал;
- 6.2.4 Хуралд оролцсон байдал;
- 6.2.5 Ажлын хэсэг, ажлын багт, ажил үүрэг хүлээж ажилласан байдал;
- 6.2.6 Намаас сонгуульд өрсөлдсөн, сонгуульд ажилласан байдал;
- 6.2.7 Намаас зохион байгуулсан улс төрийн акц, сургалт болон бусад арга хэмжээнд оролцсон байдал;

6.3 Тандалт үнэлгээний ажлын хэсгийн дарга энэ журмын 5.3-т заасан мэдээллийг захиалан гаргуулж авахдаа тандалт үнэлгээ хийлгэж буй нийт гишүүний жагсаалтаар мэдээллийг бүрдүүлүүлж авах бөгөөд аливаа гишүүнтэй холбогдолтой мэдээллийг алагчилж түүж авах, эсхүл авахгүйгээр орхигдуулахыг хориглоно.

Долоо. Үнэлгээнд тооцохгүй байх

7.1 Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам нь төрийн албанд шударга, ёс зүйтэй, багаар ажиллах чадвартай улс төрчийг дэвшүүлэх үүднээс Тандалт үнэлгээний ажлын хэсэг нь плейжеризм буюу бусдын санаа, ажил, хийсэн бүтээснийг өөрийн болгож тайлagnаж ирүүлсэн, баримт бичгийг хурамчаар бүрдүүлсэн, хууран мэхэлсэн болон хувийн ашиг сонирхлын төлөө ажилласан байдлыг үнэлгээнд оруулахаас татгалзан хасна.

7.2 Доорх мэдээллийг үнэлгээнд оруулахгүй хасна. Үүнд:



- 7.2.1 Тайлagnаж ирүүлсэн ажлын нэг буюу хэд хэдэн ажил нь бусдын санааг хуулсан нь нотлогдож байвал;
 - 7.2.2 Багаар буюу өөр гишүүний хийсэн ажлыг ганцаараа бүтээсэн ажил мэт тайлagnасан байвал;
 - 7.2.3 Намтар, боловсрол, хийсэн ажлын талаар хуурамч мэдээлэл өгсөн, эсхүл өгсөн мэдээллээ баримтаар нотолж эс чадвал;
 - 7.2.4 Эрх мэдлээ хэтрүүлсэн, өөрт нь багийн шийдвэр, тушаалаар олгогдоогүй эрхийг эдэлж гүйцэтгэсэн ажлыг;
 - 7.2.5 Нийт хамт олны дунд нээлттэй зарласан боломжоос зохих хэр хэмжээнээс илүүтэйгээр булаан хүртсэн байдлыг тус тус үнэлгээнд оруулахгүй хасч тооцно.
- 7.3 Намын дотоод мэдээлэл, гишүүдийн жагсаалт, намын дотоод харилцааны сүлжээг ашиглан залилан мэхэлсэн мэдээлэл түгээсэн, эсхүл ийм аргаар өөрт ашиг олох, давуу байдал үүсгэх зорилготой үйлдэл хийсэн бол тус гишүүний авсан нийт оноог хүчингүй болгож болно.

Найм. Журам хүчин төгөлдөр болох

Энэхүү журам нь 2024 оны 3 сарын 17-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.